

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2009 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2011.03.31.

Баянхонгор

Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх үр дүнг үнэлэх журмын дагуу Баянхонгор аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2010 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийлээ.

1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ

А. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат болох 2007-2015 онд хэрэгжүүлэх зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдээс аймаг орон нутагт холбоотой 17 зорилтыг хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилт 90,5 хувьтай хэрэгжсэн.

Б. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний аймгийн Засаг даргад даалгасан нийт 112 заалтыг хяналтад авч хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж дөрвөн жилийн дундажаар тооцон үнэлгээг гаргахад дөрвөн жилийн хөтөлбөрийн эхний 2 жилийн хэрэгжилт 57,05 хувьтай үнэлэгдсэн байна.

В. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцоход 2010 оны байдлаар төрийн захиргаа удирдлагын салбарт 2, хууль эрх зүйн салбарын хүрээнд 5, байгаль орчны салбарт 9, нийгмийн салбарт 25, Хүнс, хөдөө аж ахуйн салбарт 8, үйлдвэрлэл, дэд бүтэц, эрчим хүчний салбарт 8 хөтөлбөр нийт 57 үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцоход 90-100 хувьтай хэрэгжилттэй байгаа бөгөөд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн дундажийг тооцоход дундаж нь 92.6 хувьтай гарч байна.

2. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ

А. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн аймаг, орон нутагтай холбоотой 45 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг тооцон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд бодлогын зорилтод хүрсэн буюу үйл ажиллагаа нь 100% хэрэгжсэн 38 заалт, 90 хувийн хэрэгжилттэй 2 заалт, 70 хувийн хэрэгжилттэй 5 заалт байгаа бөгөөд заалтуудын дундажаар үндсэн чиглэлийн хэрэгжилт 96,22 хувьтай байна. Бусад заалтын хувьд аймаг орон нутагт хэрэгжилтийг тооцох боломжгүй буюу улсын хэмжээнд хэрэгжүүлэх заалтууд байна.

Б. Аймгийн хэмжээнд 2010 онд Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаварын нийт 104 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг авч үзэхэд 100 хувийн биелэлттэй 68, хэрэгжих шатандаа байгаа 36 тогтоол байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж нь 94 хувьтай байна.

Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг тооцон гаргахад 100 хувийн биелэлттэй буюу бүрэн хэрэгжсэн 21, хэрэгжих шатандаа байгаа 5 тогтоолын биелэлт 98 хувьтай биелсэн байна.

В. Аймгийн Засаг даргын 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 182 заалтын 2009, 2010 оны хэрэгжилтийг тооцоход 67,5 хувьтай хэрэгжсэн байна. Хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудад хөрөнгө санхүүтэй холбоотой туссан заалтуудын хэрэгжилт удааширсан байна.

3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ

А. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

№	Сайд, аймгийн Засаг даргын гэрээ	Үнэлгээ	
		Хувь	Оноо
1	Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний биелэлт	87,1%	4,36
2	Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	85,0%	4,25
3	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	98,56%	4,92
4	Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	86,60%	4,33
5	Хууль зүй дотоод хэргийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	98,5%	4,92
6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	100,0%	5,00
7	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	76,3	3,81
8	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлт	94,10	4,70
	Үнэлгээний дундаж	87,59	4,54

Б. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй аймгийн Тамгын газрын хэтийн болон жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат бүтээгдэхүүнээс бусад нийт 8 үндсэн зорилтын хүрээнд 33 бүтээгдэхүүний нийлүүлэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн

шалгуур үзүүлэлт / тоо хэмжээ, чанар, хугацаа, өртөг/-ийн болон хүрэх үр дүн/үр дагавар/-ийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцсоны үндсэн дээр үнэлэхэд:

- Нийт бүтээгдэхүүний нийлүүлэлт 27,5
- Тусгай захиалгат бүтээгдэхүүний нийлүүлэлт 32,4
- Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх зорилтын биелэлт 30,0 буюу нийт 89,9 оноогоор “В” буюу “Сайн” үнэлэгдсэн байна.

4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын захирамжаар батлан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хэрэгжилтийг дүгнэж үзэхэд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын 7 заалтын хэрэгжилтийн дундаж 100 хувь, хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдлын 6 заалтын хэрэгжилтийн дундаж 100 хувь, төсөв, санхүүгийн ил тод байдлын үнэлгээний хэрэгжилтийн 7 заалтын дундаж 97,1 хувь, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын 10 заалтын дундаж 100 хувьтай нийт заалтуудын дундаж нь 99 хувьтай хэрэгжиж байна.

5. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ

А. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээг журмын дагуу үнэлэхэд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж нь хувь буюу оноотойгоор аймгийн ИТХурлын хуралдаанаар дүгнэсэн.

Б. Хэрэглэгчийн үнэлгээ : 89,7 хувь буюу 4,49 оноотойгоор үнэлэгдсэн байна.

Аймаг орон нутагт 2010 онд хийгдсэн ажлуудаас дурьдахад Аймгийн нийт хүн ам 80858 болж өнгөрсөн оноос 0,01 хувиар өссөн бөгөөд нийт хүн амын 46,0 хувь нь төв суурин газар, 54,0 хувь нь хөдөө амьдарч байна.

Аймгийн төсөвт байгууллагууд 2010 онд 21,6 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 23,7 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж төсвийн орлогын дүн 3,6 тэрбум төгрөг болж өнгөрсөн оныхоос 240,1 сая төгрөгөөр буюу 7,1 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 2010 онд улс ын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр барилга байгууламж шинээр барих болон их засварын ажилд 9.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай 26 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч 300,6 сая төгрөгийн автомашин, компьютер тоног төхөөрөмжийг сумдад нийлүүлээ.

Мал тооллогын дүнгээр 2010 онд аймгийн хэмжээгээр 1962,9 мянган толгой мал тоолуулснаас тэмээ 30,0 мянга, адуу 77,3 мянга, үхэр 101,5 мянга, хонь 543,8 мянга, ямаа 1213,3 мянган толгой тоологдож өнгөрсөн оныхноос 26,9 хувь буюу 721,7 мянган толгойгоор буурсан байна. Малын тоо зудын гамшгийн улмаас 634501 толгойгоор өнгөрсөн оны мөн үеээс буурсан дүнтэй байгаа ч Эрдэнэцогт сум мал сүргээ 102290 болгож өсгөсөн.

2010 онд 2492,0 тн төмс, 1194.5 тн хүнсний ногоо, 336.4 тн ногоон тэжээл хураан авсан нь ургац өмнөх жилээс 716.4 тн-оор нэмэгдэж аймгийн хүн амын хүнсний хэрэгцээт төмсний 73 хувь, хүнсний ногооны 27.7 хувийг хангалаа.

Өвөлжилтийн бэлтгэл хангах, мал аж ахуйн материаллаг баазыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4788.1 тн хадлан, 893.6 тн гар тэжээл бэлтгэн, 466.3 тн тэжээлийн ургамал хураан авч 229 хашаа хороо барьж, инженерийн хийцтэй уст цэг 9 - ыг шинээр, 86 энгийн уурхайн худаг гаргасан байна.

Хур тундас нэмэгдүүлэх зорилгоор Жаргалант сумын 2-р багийн нутаг “Нуурын хар үзүүр”-т “Газрын генератор” төхөөрөмжийг суурилуулсан.

Төрийн байгуулалтын талаар: Аймгийн Засаг дарга нийт 20000 өрхөд албан захидал илгээж аймаг, сум, багийн түвшинд болон иргэдэд тулгамдаж буй асуудлаар санал асуулга авч аймгийн нийгэм, эдийн засгийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгалаа. Энэ нь төр-иргэдийн холбоог бэхжүүлэх, мэдээллийг хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, төрдөө итгэх итгэлийг нэмэгдүүлсэн дорвитой ажил болсон.

Аймгийн хэмжээнд 3681 төрийн албан хаагч ажиллаж байгаа бөгөөд “Төрийн байгууллагад ажиллагсадын сахилга хариуцлагыг өндөржүүлэе” аймгийн 2 дугаар зөвлөлгөөн хийж төрийн болон төсөвт байгууллагуудад гарч буй нийтлэг зөрчил дутагдлыг зааж нийт иргэд бүх шатны Засаг дарга, ИТХурлын дарга, ерөнхий менежерүүдэд хандаж гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх албан даалгавар гаргаж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Манлайллын сургалтыг 160 шахам төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдэд явуулж “Суралцагч байгууллагыг хөгжүүлэх” нь сэдэвт аймгийн удирдлагуудыг оролцуулсан “Онол

практикийн бага хурал зохион байгуулж сум байгууллагын хөгжлийн талаар илтгэл тавигдсан нь онол арга зүйн хувьд шинэлэг ажил боллоо.

Төрийн байгууллагуудад төрийн албаны стандарт мөрдөлтийг нэг мөр болгон хэрэгжүүлэх зорилгоор ажлын ерөнхий түвшингээр харьцангуй бусдадаа үлгэр дуурайлал болохуйц гэж үзсэн Жаргалант Бууцагаан суманд 20 сумын бүх ерөнхий менежерүүдийг оролцуулсан үзүүлэх сургууль зохион байгуулсан нь зохих үр дүнгээ өгч байна.

Хүний хөгжлийг хангах зорилгоор урт болон богино хугацааны зорилтот сургалтад 103 төрийн албан хаагчийг төлөвлөгөөний дагуу хамруулж удирдлагын академид 43 хүн суралцаж байна.

Иргэний шинэчилсэн бүртгэлийг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд “Иргэний баримт бичгийн үзлэг” хийх сарын аян зохион байгуулж үзлэгт аймгийн нийт хүн амын 91,3 хувийг хамруулж бичиг баримтын 10746 зөрчил илрүүлж зөрчлийн 96,7 хувийг бүрэн арилгаж мэдээллийг иргэний бүртгэлийн мэдээллийн санд бүртгэн баталгаажуулсан.

Иргэдийн хурууны хээ болон биеийн өгөгдөл авах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж одоогоор бүртгэгдвэл зохих насанд хүрсэн 54532 иргэнээс 51860 иргэнийг бүртгэж хамрагдалт 95,1 хувьтай, насанд хүрээгүй 26318 иргэнээс 26250 иргэнийг бүртгэж иргэний шинэчилсэн бүртгэлийн хамрагдалт 99,7 хувьтай байна.

Боловсролын салбарын хүрээнд: Сургуулийн 6-15 насны хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн суурь боловсролын хамран сургалтыг 99 хувьд, цэцэрлэгийн насны 6466 хүүхдээс хамран сургалтыг 78 хувьд хүргэн өмнөх оныхоос 2 хувиар өсгөж 2008-2009 онд бага боловсролын сургууль завсардалт 24 хувийг эзэлж байсныг 2009-2010 оны хичээлийн жилд 12 хувь болгон өмнөх оныхоос 50 хувиар буурууллаа.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн стандарт хангалт, сурлагын амжилт 10-12 хувиар, чанар 2-2,7 хувиар өссөн байна.

Баянхонгор аймгийн Өлзийт сумын уугуул Монгол Улсын төрийн шагналт, гавъяат багш, академич, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Шадавын Лувсанвандангийн мэндэлсний 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэх ажлын хүрээнд монгол хэл бичгийн болон сэтгэх чадварын улсын олимпиадуудыг аймагтаа зохион байгуулсан.

Баянхонгор сумын 7-р багт 75 хүүхдийн цэцэрлэг баригдаж, Баянцагаан, Бууцагаан сумын соёлын төвийг шинээр барих ажил эхлээд байна.

Аймгийн ардын урлагийн наадмыг 2 үе шаттайгаар зохион байгуулж нэгдсэн Гала тоглолтод 6 төрлөөр 140 гаруй авъяастан оролцлоо.

Аймгийн Хөгжимт драмын театрын засварт С.Лувсанвандан сангаас 35,0 сая төгрөгийн, төсвөөс 37,6 сая төгрөг, нийт 72,6 сая төгрөгийн засвар хийж хөгжимт драмын театрт иргэдийн ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүллээ.

Эрүүл мэндийн салбарт: 50 ортой төрөх эмнэлэг ашиглалтад орж, хүүхдийн тасгийн дэргэд хүүхдийн сувиллыг “Дэлхийн зөн” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр байгуулсан.

“Өрхийн эмнэлэг, багийн эмчийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд өрхийн эмнэлгүүдэд 51,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, тохижилтын ажил хийгдэж, нийт 45 багийн эмчид өвлийн дулаан хувцас, 10 багийн эмчид мотоцикль олгосон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгааны төвийг барьж ашиглалтад оруулснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх таатай нөхцлийг бүрдүүллээ.

Эмнэлгийн ажилчдын болон төрийн алба хаагчдын орон сууц барих ажлыг “Хөх бүрдний эх” ХХКомпани гүйцэтгэж байна.

“Цахим эмнэлэг” хөтөлбөрийн тендерт шалгарсан “Залаа жаргалант” ХХКомпани шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлж нэгдсэн эмнэлэг нь Улаанбаатар хот болон бүсийн төвүүдийн эмнэлгүүдтэй сүлжээнд холбогдож эмчилгээ оношлогоонд мэдээллийн технологийг ашиглах нөхцлийг бүрдүүллээ.

Хөдөлмөр эрхлэлт, иргэдийн нийгмийн хамгааллыг салбарт: Аймгийн нийт хөдөлмөрийн насны хүн амын дийлэнх хэсгийг хөдөлмөрийн насны залуучууд эзэлж байна. Энэ үед тохирсон хөдөлмөр эрхлэлтийн зөв бодлого нь улс орнуудын хурдацтай хөгжих үндэс болдог. Бид энэ байдалд дүгнэлт хийж Баянхонгор аймгийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” 2021 он хүртэлх хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 2010 оны 128 дугаар захирамжаар батлан хэрэгжүүлснээр 1882 хүнийг ажлын байртай болгосны 1043 хүн нь байнгын ажлын байртай болсон. Аймгийн хэмжээнд 2011 оныг “Үйлдвэрлэлжилтийг дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарлаж ажлын төлөвлөгөө гарган ажиллаж эхлээд байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1 жил буюу түүнээс дээш хугацаагаар ажилгүй байгаа 63 иргэнийг ажлын байраар хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулж байгаа 14 аж ахуйн нэгж, байгууллагад 47,1 сая төгрөгний ажил олгогчийн урамшууллыг олгож ажиллаа.

Ажилгүйдлийн түвшин 2010 онд 5.8 хувь болж 2009 оноос 1.6 хувиар буурч, ажил идэвхтэй хайж бүртгүүлсэн ажилгүйчүүдийн тоо 2291 болж урд оноос 23,5 хувиар буурснаас 60,7 хувь буюу 1390 нь эмэгтэйчүүд байна.

Аймгийн хэмжээнд 450 өрхийг ядуурлаас гаргах зорилтын хүрээнд сум бүрт 20 өрхийг, Баянхонгор сумд 70 ядуу өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхээр сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллаж, эдгээр өрхийн гишүүдээс 235 иргэнийг чадваржуулах сургалтад, 132 иргэнийг мэргэжил олгох, 19 иргэнийг бизнесийн санаа хөгжүүлэх сургалтад суулгаж 18 сумын 108 иргэнийг нийтийг хамарсан ажилд хамруулсан .

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд 98 өрхийн 147 иргэнийг хамруулж 98,6 сая төгрөг олгосны дүнд 147 ажлын байр шинээр бий болж 595 хүний орлогыг нэмэгдүүллээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтийн хөтөлбөрөөр Шинэжинст, Эрдэнэцогт, Галуут сумын 16 малчин өрхийг чадваржуулах сургалтад хамруулж, материаллаг баазыг сайжруулах, хосолсон аж ахуй эрхлүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн 47.3 сая төгрөгийг зарцуулан, загвар малчин өрхийг бий болгосон.

2010 оны өвөл цаг агаарын байдал хүндэрсэнтэй холбогдуулан хөдөө орон нутагт байгаа ажилгүй иргэдийг туслах малчнаар ажиллуулах, малын өвс тэжээл ачиж буулгах, малын хашаа, хороо дулаалах, зам даваа, гүвээ чөлөөлөх зэрэг нийтийг хамарсан ажилд 1005 хүнийг оролцуулан, хөдөлмөрийн хөлсөнд 83.7 сая төгрөгийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас зарцууллаа.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 11 сургалтын байгууллагад 61.7 сая төгрөгийн санхүүжилт хийж 15 төрлийн мэргэжлээр 27 удаагийн сургалт явуулж сургалтад хамрагдсан 639 иргэн мэргэжил эзэмшүүлсэн.

2010 онд Баянхонгор аймагт ОНОТХҮ-ний хүрээнд нийтдээ 20 сумын 127 өрхийн 153 иргэний санаачилсан 39 бүлэгт халамжийн сангаас 32,7 сая төгрөгний санхүүгийн дэмжлэгийг үзүүлэн 1 жилийн хугацаанд гэрээ байгуулан ажилласны үр дүнд 126 өрхийн амьжиргаа дээшилж, ажилгүй иргэд бүлэг зохион байгуулалтад орж ажиллахын давуу талыг мэдэрч, хамтран ажиллаж байна.

Хүний хөгжил сангийн тухай хууль батлагдан гарч, Монгол улсын иргэн бүрт хишиг, хувь олгох ажлыг 2010 оны 02 дугаар сарын 01-нээс эхлэн зохион байгуулах болсонтой холбогдуулан УИХ-ын 2009 оны “Хүний хөгжил сангаас Монгол улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувь хэмжээг тогтоох тухай” 99-р тогтоол, “Иргэний шинэчилсэн бүртгэл явуулах тухай” 100-р тогтоол,

Засгийн газрын “Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 3-р тогтоолын дагуу хишиг хувь хүртээх ажлыг хөнгөн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй олгоход анхаарч ажилласнаар 81140 хүнд 8549,1 сая төгрөгийн хувь хишиг тараасан.

Нийгмийн халамжийн сангаас 2307 хүнд 1096,9 сая төгрөгийн тэтгэвэр, 1572 хүнд 437,9 сая төгрөгийн нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжид хамрагдаж 437.9 сая төгрөг, нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 1554 иргэнд 178.3 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 4288 ахмад насанд 311,9 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 1959 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 167.0 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, алдар цолтой 24 ахмадад 5.1 сая төгрөгийн, алдарт эхийн 1-р зэргийн одонтой 1243 эхэд 248,7 сая, 2-р зэргийн одонтой 3379 эхэд 337,9 сая төгрөгийн мөнгөн тусламж олгосон.

Нийгмийн даатгалын сангаас 10302 хүнд 10105,7 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, 76526 иргэнд 2004,0 сая төгрөгийн эмчилгээ үйлчилгээ, эмийн хөнгөлөлт үзүүлж, өмнөх оны хуримтлагдсан өр авлагыг 53,4 хувь буюу 46614,2 сая төгрөгөөр буурууллаа.

Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн хууль тогтоомжийг сурталчилан таниулж, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилт тавин ажилласнаар 17041 хүн нийгмийн даатгалд хамрагдаж 183,3 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалд 13420 хүн хамрагдаж 80,5 сая төгрөгийн орлого оруулж, иргэдийн нийгмийн хамгааллыг бий болголоо.

Хууль, эрх зүйн салбарт: Аймгийн Засаг даргын 2009 оны 111 дүгээр захирамжаар “Архидан согтуурахтай тэмцэх ажлыг үлгэр жишээ зохион байгуулж байгаа “Жишиг сум шалгаруулах болзол”-ыг батлан бүх сумдад хүргүүлснээр сумдууд “Жишиг сум” болох ажлын төлөвлөгөө гарган ажиллав. Болзлын биелэлтийг 2010 оны 01 дүгээр сард дүгнэж Богд, Бууцагаан, Галуут сумдыг аймгийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан.

- 2010 онд аймгийн хэмжээнд авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийг хууль хяналт, авилгад өртөж болзошгүй эрсдэлтэй байгууллагын дарга нар, сумдын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, ажлын хэсгийн ажиллах журмыг боловсруулан аймгийн Засаг даргын 2010 оны 281 дүгээр захирамжаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Авилгатай тэмцэх газар болон АНУ-ын Азийн сангаас зохион байгуулсан семинараас гарсан зөвлөмжийн дагуу тус аймагт авлигаас урьдчилан

сэргийлэх 2010 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Авилгатай тэмцэх тухай хуулийн дагуу Төрийн албан хаагчдын ХОМ-ийг зохих хугацаанд нь АТГ-т хүргүүлэн ажиллаж байгаа ба 2009 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ хугацаанд нь гаргаж өгөөгүй төрийн нэг албан хаагчид аймгийн Засаг даргын захирамжаар сахилгын арга хэмжээг авлаа.

Хууль зүйн хэлтэс нь эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны төлөвлөгөөний дагуу байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнууд, албан газрын дарга, эрхлэгч, төлбөрийн чадваргүй болон Цагдаагийн хэлтэст эрүүлжүүлэгдсэн иргэд зэрэг нийт 230 орчим хүнд төлөвлөгөөт; сум, байгууллагын удирдлагуудын хүсэлтээр 290 хүнд захиалгат эрх зүйн албан бус сургалтыг Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хийж, хууль тогтоомжоор бэлтгэсэн 3-5 төрлийн хялбаршуулсан 6000 гаруй гарын авлагаар оролцогчдыг хангав.

Төрийн архивын үйл ажиллагаанд Архивын Ерөнхий газраас “ORMS” бүртгэл хайлтын программыг авч, бүртгэл хайлтын программд Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа баримтын хөмрөгийн жагсаалт, тоо бүртгэл мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын 1941-2000 оны 2502 баримтын бүртгэл, өгөгдлүүдийг оруулж хадгалсан ба зарим нэр төрлийн баримтуудаар тусгайлан файл үүсгэн хадгалж эхлээд байна.

Мөн Аймгийн Засаг даргын Тамгын газарт албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийн программыг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, сургууль, хүн эмнэлэг зэрэг төсвийн 80 байгууллагад 16.0 сая/төг-ийн үнэ бүхий байгууллагын архивын программыг нэгдсэн журмаар суулгуулан, ажилтнуудыг иж бүрэн сургалт-дадлагад хамруулан, программыг үйл ажиллагаандаа хэрэглэж эхлэв.

-Төрийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 182 дугаар захирамжаар нийт 1168000 төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэн, сан хөмрөгт байгаа дуу дүрсний баримтыг дахин хуулбарлах, аймгийн Засаг даргын Тамгын газрын 1941-2000 оны 2502 баримт, цуглуулга, хууль, эрх зүйн болон фото зургийн зэрэг нийт баримтуудыг хамгаалах хайрцагт шилжүүлэх, мөн хуулбар хувь бэлтгэх, Үндсэн цахим санд хамгаалалтын сейф, хавтастай болгох зэрэг ажлыг хийлээ.

-Аймгийн Засаг даргын Тамгын газар нь Архивын Ерөнхий газартай хамтран “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга

замын талаар туршлага судлах зорилготой улсын хэмжээний анхны үзүүлэх сургалт-семинарыг 06 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Батлан хамгаалах салбарт:

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр манай аймагт барилга-инженерийн Зэвсэгт хүчний 339 дүгээр анги шинээр байгуулагдсан нь зөвхөн өөрийн аймгийн төдийгүй баруун бүсийн аймгуудын бүтээн байгуулалтад цэргийн албан хаагчдыг татан оролцуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тус ангийг түшиглэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, орон нутгийн цэргийн сургалтыг явуулах боломж бүрдлээ.

Манай аймгийн төвд “ Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах өдрүүд, “ Дотоодын цэргийг сурталчлах өдөрлөг “, Хилийн цэргийн 0166 дугаар ангийг сурталчлах бүсчилсэн “ Урлаг спортын нэгдсэн өдөрлөг “ Баацагаан, Жаргалант сумдын төвд болж, хүүхэд залуучууд, иргэд өргөнөөр оролцсон нь тэдэнд эх оронч үзэл төлөвшүүлэхэд чиглэгдсэн томоохон арга хэмжээ боллоо.

Аймгийн Засаг даргаас санаачлан “ Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдын Засаг дарга нартай цэргийн бэлтгэл сургалт “-ыг явуулж, Говь-Алтай аймагт Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан “ Баруун бүсийн аймгуудын Засаг даргын Тамгын газрын дарга нартай явуулах цэргийн бэлтгэл сургалт “-нд сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг оролцуулсан нь нутгийн захиргааны албан тушаалтнуудын цэргийн бэлтгэлийг дээшлүүлэхэд үр нөлөөтэй ажил болсон юм.

2008-2010 онд цэргийн дүйцүүлэх албыг хааж байгаа 36 иргэнийг аймагт татан ирүүлж, үүнээс 8 иргэнийг Онцгой байдлын хэлтсийн улсын нөөцийн салбарт ажиллуулж, 200 тн будаа буулгуулан агуулахад зөөвөрлөн оруулж, 3000 шуудай будаа савлах, Баян-Өндөр сумын нутагт 28 цэргийн дүйцүүлэх алба хаагч Таван - Овооны 7км, Үрээгийн хөндий 18 км нийт 25 км зам засварын ажилд 6 хоног ажилласан. Зам засах ажил нь тус аймгийн Баян-Өндөр сумын нутагт Амарбуяангийн хийд анх үүсэн байгуулагдсаны 315 жил, дахин сэргэсний 20 жил, Гүшири хувилгаан Данзинчойжийнямааг хүндэтгэн сэнтийд нь залах баярын үйл ажиллагааны бэлтгэл болон орон нутгийн бүтээн байгуулалтанд оролцсон ажил юм.

Аймгийн Засаг даргын 2010 оны 141 дүгээр захирамжийн дагуу сумдад цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа 85 хүнийг малын сэг зэм устгах ажилд татан оролцуулж, цэргийн дүйцүүлэх алба хаагч 50 хүнийг Өлзийт сумын Гялгарын давааны замыг засах ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

Цэргийн дүйцүүлэх алба хаагч 40 хүний хүчээр Баян-Овоо сумын төвөөс хойш 5 км – т орших “Талын Улаан” гэдэг газар нөөц бэлчээр байгуулж, мал идээшлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 1 х 1,5 х 300 м туршилтын хөмөг байгуулсан нь гамшгаас урьдчилан сэргийлэх хүрээнд хийгдсэн ач холбогдолтой нэгэн ажил боллоо.

Жижиг дунд үйлдвэрийн хөгжил:

2010 онд Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэлээр 73 төсөлд 885,9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноос хүнсний салбарт 21, МAA-д 26, газар тариаланд 7, хөнгөн үйлдвэрлэлд 9, барилгын салбарт 4, ахуйн үйлчилгээний чиглэлээр 6 төсөлд хөнгөлөлттэй зээлийг олгож нийтдээ 360 гаруй ажлын байр хадгалагдан үлдэж 28 үйлдвэр үйлчилгээний салбар нэмэгдэж 200 орчим ажлын байр шинээр бий боллоо.

Сүүлийн 2 жилд нийтдээ 150 гаруй төсөлд 1,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосны дүнд байгуулагдсан зарим жижиг дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж байна.

Аймгийн төвийн ойролцоо сайн үүлдрийн саалийн үнээний 2 ферм байгуулагдан амжилттай ажиллаж, хулдаасан хэвлэлийн цех шинээр ашиглалтад орж, ахуйн үйлчилгээний цэг салбаруудын үйл ажиллагаа өргөжиж, аялал жуулчлалын бааз байгуулагдан, байгалийн чулуугаар төрөл бүрийн барилгын материал, цонхны тавцан зэргийг үйлдвэрлэдэг чулууны үйлдвэр ашиглалтад орж, барилгын материалын үйлдвэр өргөжин хөгжиж, хөдөөгийн 16 сумд талх нарийн боовны цехүүд, Баацагаан, Галуут зэрэг сумд сүү цагаан идээний жижиг үйлдвэр цехүүд ажиллаж байна.

Аймгийн төвд Энэтхэг улс ын тоног төхөөрөмж бүхий өдөрт 4.0 тн хүртэл сүү боловсруулах хүчин чадалтай сүүний үйлдвэр, Баянлиг сумд өдөрт 500 л ингэний сүү ариутган савлах цех ашиглалтад орж Баянхонгор аймгийн төвд халуун ханзаар халдаг Америк загварын хүлэмжийг шинээр байгуулан ашиглалтад оруулсан нь Монгол улсад анхных нь боллоо.

2011 онд жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн төв байгуулж Аж үйлдвэрийн паркийн ажлын эхлэлийг тавьж мах боловсруулах 2 үйлдвэр, ноос угаах үйлдвэрүүдийг ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Сум бүрт жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэлээр 50,0 сая төгрөг, Баянхонгор сумд 200,0 хүртэл сая төгрөг олгогдох бөгөөд 2009, 2010 онуудад олгосон хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлтийн мөнгийг үйлдвэр хөгжүүлэх төслүүдэд эргүүлэн ашиглах юм.

Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцааны чиглэлээр:

Аймгийн 19 сумын нутагт 53 гол горхи, 50 булаг шанд, 23 нуур цөөрөм, усны сан бүхий газруудад 1932 цэг дээр солбицол авч баримтжуулж говийн бүсэд усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг 1000 метрээр, хангайн бүсэд 200-2500 метрээр тогтоож Улсын төсвийн хөрөнгөөр 6 булагийн эхийг хамгаалахад 12 сая төгрөгийг зарцууллаа.

Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд нөхөн сэргээлтийг заавал хийлгэх шаардлага тавьсны үр дүнд Баян–Овоо суманд үйл ажиллагаа явуулж буй “Андын тэмүүлэл” ХХК - 5,1 га, Таван хангал трейд” ХХК - 2 га, Бөмбөгөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Бадамлах очир” ХХК - 28,5 га, “Дальня земля” ХХК - 0,5 га, “Хайтек” ХХК - 2,5 га, “Ханшижир” ХХК - 26,2 га “Одод гоулд” ХХК Цагаан тохойд - 4,43 га, Галуут суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Монголболгаргео” ХХК - 18 га, “Тулгажаргалант” ХХК - 17 га, Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Жамп” ХХК 23 га-д техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж мэргэжлийн байгууллагад тус тус хүлээлгэж өгөөд байна.

"Хонгор -1000" орон сууцны хороолол барих газрын байршлыг 3-р багийн нутаг дэвсгэрт 4-р сургуулийн орчимд сонгож байршлын зургийг гаргаж, төлөвлөлтийн ажлыг хийж Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "100 мянган айлын орон сууц" хөтөлбөр төслийн хүрээнд /2010-2015 онд/ 440 хүүхдийн сургууль, 50 хүүхдийн цэцэрлэг, 120 хүнд үйлчлэх хүчин чадалтай ахуйн үйлчилгээний төв, 300 суралцагчтай МСҮТөв, өдөрт 30 хүнд үзлэг хийх хүчин чадалтай өрхийн эмнэлэг барихаар төлөвлөгдсний дагуу барилга байгууламжийн байршлын зураг гаргаж 200 айлын орон сууц, барих ажил эхлээд байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу 1840 иргэнд 516 га газрыг өмчлүүлсэн.

Баянхонгор сумын газрын доорхи барилга байгууламж инженерийн шугам сүлжээнд тооллого хийгдснээр 12000 м шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ажил эхлэхээр зургийн тендер зарлагдаж гүйцэтгэгч "ДНТ" ХХК -ны мэргэжилтнүүд ирж газар дээр нь хэмжилт хийж трассын зураглал гаргаж 2011 оноос ажил эхлэхээр шийдвэрлээд байна.

Шинэжинст сумын Хотгорын нүүрсний ордыг түшиглэн говийн бүсэд дулааны цахилгаан станц, нүүрс угаах болон коксны үйлдвэр барих саналууд ирж Шинэжинст сумаас Өмнөговь аймгийн Гурвантэс сум хүртэл 314 км хатуу хучилттай замын зураг төсөв хийгдэн замын ажлыг 6 дугаар сарын 01-нээс эхлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ТАСГИЙН ДАРГА М.ӨНӨРЖАРГАЛ

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ч.ГОМБОДОРЖ